



Батлав. Монгол хэл бичгийн улсын олимпиад
зохион байгуулах дэд хорооны дарга
Д.Соронзон (Ph.D)

МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН I ДАВААНЫ IX АНГИЙН СУРАГЧДЫН СЭДЭВ

Оноо 27. Хугацаа 90 минут

Санамж:

1. Даалгавруудыг эх сэдэв дээр биш, тусгай цаасан дээр гүйцэтгэнэ.
2. Ажил тус бүрийн дугаар, дэд дугаарыг тодорхой бичнэ.

Даалгавар гүйцэтгэхэд ашиглах эх

...Монгол лин Гэсэрийн туужид Гэсэр хаан алс хойд зүгээс Төвөд оронд халдаж ирсэн мангасыг эсэргүүцэн байлдаж хэдэн жил гадаад оронд суусныг өгүүлнэ. Гэсэрийн хийсэн хойд зүгийн байлдаан гэдэг нь юу вэ? гэж асууж болно.

Бурхны шашинтан төвөд, уйгур, монгол угсаатан нийлж, Гэсэр хааны цэрэг болж, Төвөд оронд халдсан дайсан лалын шашинтан карлук угсаатны өөдөөс байлдан тэмцсэн түүхийг Гэсэрийн туужид хойд зүгийн байлдаан хэмээн үзүүлж байх бололтой байна. Энэ байлдаанд Гэсэрийн шадар жанжин нь Гадар Чин-он гэдэг хүн байсан гэж төвөд Гэсэрийн туужид гарна.

Дорнод Туркестаны түүхийг үзвэл үнэхээр 11 дүгээр зууны эхний үед бурхны шашинтай Хотань хотод Кадыр гэдэг хаан байсан бөгөөд лалын шашинтай карлук угсааны ах дүү нартайгаа тэмцэлдэж байсан түүх байх юм. Эдгээр баримтыг үндэслэн, Гэсэр хааныг 11 дүгээр зууны үед байсан гэж тааварлаж болох юм. Эцсийн дүгнэлт бол өөр тулгар бичгүүдээр нотлох хэрэгтэй. Ийнхүү шалгаж магадлах тулгар бичгүүд нь гэвэл Төвөд, Монгол ба Хятадын түүхийн зохиол, оны тэмдэглэл, ардын домог зэрэг болно. (Ц.Дамдинсүрэн. “Гэсэрийн туужийн түүхт чанар”)

Нэг. Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

1.1. Эхийн хэв маягийг оновчтой тодорхойлсон хэсэг аль вэ? (2 оноо)

- А. Ц.Дамдинсүрэн өөрийн бодлыг өгүүлсэн хүүрнэсэн эх.
- Б. Гэсэрийн туужийн гол дүр түүхт хүн байсан тухай таамаглан тайлбарласан эх.
- В. 11 дүгээр зууны үеийн Туркестан улсын тухай тоочин тайлбарласан эх.
- Г. Гэсэр хааны хийсэн аян дайны талаар дүрслэн тайлбарласан эх.

1.2. Эхийн бүтцийг зөв тодорхойлсон хэсэг аль вэ? (2 оноо)

- А. Эхийг асуултаас үзэл бодол, үзэл бодлоос, санал, саналаас нотолгоо гэсэн хэсэгтэй бичжээ.
- Б. Эхийг ажиглалтаас үүдсэн асуулт, асуултаас дүрслэл, дүрслэлээс дүгнэлт гэсэн хэсэгтэй бичсэн байна.
- В. Эхийг дүрслэл, дүрслэлээс нотолгоо, нотолгооноос дүгнэлт гэсэн уялдаат хэсэгтэй бичсэн.
- Г. Эхийг ажиглалтаас үүдсэн асуулт, асуултаас таамаглал, таамаглалаас санал, саналаас нотолгоо, нотолгооноос дүгнэлт гэсэн хэсгээр уялдуулан бичжээ.

1.3. Дээрх даалгавар (1.2)-ын зөв хариултад тохирох жишээ тус бүрийг эхээс ялган бичиж, батлаарай. (3 оноо)

1.4. Эхээс баймж утгатай 2 жишээ олж, тус бүрийн утгыг тайлбарлаж бичээрэй. (2 оноо)

1.5. Эхийн төгсгөл хэсэгт буй “тулгар бичгүүд” гэсэн холбоо үгтэй адил утгатай хэсгийг олоорой. (1 оноо)

А. тулгар эх Б. тулгар төр В. тулгар баримт Г. тулгар дараа ирэх

1.6. Дараах хэсэгт байгаа зурж онцолсон үгийн зөв бичгийн дүрмийг тайлбарлаж бичээрэй. (2 оноо)

“...төвөд, уйгур, монгол угсаатан, ...төвөд Гэсэрийн туужид гарна”, “Төвөд оронд халдсан,... Төвөд, Монгол ба Хятадын түүхийн зохиол...”

Хоёр. Даалгаврыг гүйцэтгээрэй.

2.1. “Гэсэр хааны тууж”-д өгүүлсэн, Гэсэрийн төрөх үеийн орчин нөхцөл, онцгой үйл явдлыг товч бичээрэй. (2 оноо)

2.2. Гэсэр хааны хатдын нэрийг бичээрэй. Дараах шүлэгт аль хатны гоо үзэсгэлэнг дүрсэлсэн бэ? (2 оноо)

Босоо бие нь ургамал нарс модыг ханхуй нэрт магнаг торгоор бүрсэн мэт.

Суугаа бие нь таван зуун хүн суух орд цагаан гэр мэт.

Баруун мөрөн дээр нь алтан шумуул эргэж байна.

Зүүн мөрөн дээр нь мөнгөн шумуул эргэж байна.

Баруунтаа наранд суувал хайлах мэт.

Зүүнтээ сарны сүүдэрт суувал царцах мэт.

Шөнийн гэрэлд нь зуун мянган агт манах мэт.

2.3. Дээрх шүлэг (2.2-р даалгавар) уран дүрслэлийн ямар, ямар аргаар бүтсэнийг тайлбарлаарай. (3 оноо)

2.4. 2.2-р даалгавар дахь шүлгийн бүтэц, санааг дуурайлган, баатар эрийн шинжийг өгүүлсэн нэг бадаг уран дүрслэл зохиож бичнэ үү. (4 оноо)

2.5. “Гэсэр хаан хойд өдөр нь бас хотын асар дээр гарч суутал Гэсэрийн Амин сахигч ах нь хэрээ болж хувилаад очив. Үдийн цагт баруунаас нэг хэрээ нисэж айсуй.” гэсэн хэсгийг үндэсний бичгээр бичээрэй. (4 оноо)